



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 9/205

Хархорин сум

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай
тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн “Үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь батлах тухай” А/96 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн “Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай А/793 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Онгоцон-Ухаа багийн Зогсоол толгой, Мөргөцөг, Харгант, Өндөр толгой, Цагаан нуур, Түркийн зам дагуух 2200 га, Жалбаа багийн Хадан хошуу, Дэлийн бүрд, Жалбаа, Өвөр элстий, Сайртын 2200 га, Шанх багийн Шар бүрд, Сарын гол, Хөшөөн дэнж, Шар замын гээг, Голын овоотын 2268 га нийт 6668 га бэлчээрт энгийн механик биологийн мэрэгчтэй тэмцэх ажлыг 2024 оны 10 дүгээр сарын 24 - ний өдрөөс эхлэн 5 хоногийн хугацаанд зохион явуулсугай.

2.Мэрэгч устгал зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, зарцуулагдах шатахуун, хөдөлмөр хамгааллын зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Мэрэгчтэй амьтантай тэмцэх ажлыг малчдаар гүйцэтгүүлж, удирдлагаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (С.Мөнхсоёл)-д даалгасугай.

4.Мэрэгчтэй тэмцэх ажлын явц, үр дүн, чанарт байнгын хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Ц.Баатарсүрэн)-д үүрэг болгосугай.

5.Мэрэгчтэй тэмцэхэд зарцуулагдах хөдөлмөр хамгааллын хувцас, шатах тослох материал, хоол хүнсний зардлыг мэрэгч устгалын ажил зохион байгуулах хөрөнгөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (О.Гангаацэрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

401100409

Хархорин сумын Засаг даргын 2024 оны
10 дугаар сарын 28 ны өдрийн 1/205 дугаар
захирамжийн 1 дугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙГ ДАРААХ БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: С.Мөнхсоёл (Бэлчээр, газар тариалангийн асуудал
хариуцсан мэргэжилтэн)

Гишүүдэд: Ч.Баттулга (Газрын даамал)
Ц.Баатарсүрэн (Байгаль орчны хяналтын улсын
байцаагч)
Э.Очир-Эрдэнэ (Архитектор)
Б.Ганхуяг (Онгоцон-Ухаа багийн Засаг дарга)
Л.Төгөлдөр (Жалбаа багийн Засаг дарга)
О.Батсүх (Шанх багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Э.Үүрцайх (Мал аж ахуйн асуудал хариуцсан
мэргэжилтэн)

--oOo--

Хархорин сумын Засаг даргын 2024 оны
10 дугаар сарын 28 ны өдрийн 14205 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

БЭЛЧЭЭРИЙН ХӨНӨӨЛТ МЭРЭГЧ АМЬТАНТАЙ ТЭМЦЭХ АЖЛЫН ТӨСӨВ (төгрөг)

Д/д	Багийн дугаар	Явах чиглэл, газрын нэр	Явах км	Зарцуулах шатахуун		Мөнгөн дүн
				ДТ 3290	АИ-92 2530	
1	5	Зогсоол толгой, Мөргөцөг, Харгант, Өндөр толгой, Цагаан нуур, Түркийн зам	900	80	70	440,300
2	6	Хадан хошуу, Дэлийн бүрд, Жалбаа, Өвөр элстий, Сайрт	1010	100	80	531,400
3	7	Шар бүрд, Сарын гол, Хөшөөн дэнж, Шар замын гээг, Голын овоот	900	80	70	440,300
4	Хяналтын шатахуун		-	40	240	804,300
5	Хөдөлмөр хамгааллын зардал		-			832,900
6	Цалин урамшуулал					2,980,800
НИЙТ ДҮН						6,030,000

--ooOoo--